



**ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС ХХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2020 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Г Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурал зарлан хуралдуулах тухай Г

Компанийн тухай хуулийн 59.2, 59.4, 59.11, 60.1, 60.2, 62.1.9, 76.1.11, “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-ийн дүрмийн 5.3, 5.4, 6.6-д заасныг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 15:00 цагт, Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Блю скай тауэрын 6 давхарт компанийн байранд зарлан хуралдуулж, холбогдох зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-ийн Гүйцэтгэх захирал /Т.Мөнхбаяр/, Төлөөлөн Удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Н.Ууганчимэг/ нар тус тус үүрэг болгосугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Санхүү хариуцсан дэд захирал Г.Ганболдыг томилж, хурлаар хэлэлцэх асуудлыг дараах байдлаар баталсугай.
- 2.1 Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн Удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт
- 2.2 Компанийн 2019 оны санхүүгийн тайланд өгсөн аудитын байгууллагын дүгнэлт
- 2.3 Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хийх бэлтгэлийг ханган зохион байгуулалтын арга хэмжээ авч, хурлаас гарсан шийдвэр, холбогдох материалыг “Эрдэнэс Монгол” ХХК-д хүргүүлж ажиллахыг “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-ийн Гүйцэтгэх захирал /Т.Мөнхбаяр/, Төлөөлөн Удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Н.Ууганчимэг/ нар тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Н.МЯГМАР



00000030